

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№21/540

ШУС, НУС

2020

**ЭРДЭМТЭН Т.БААСАНСҮРЭНГИЙН “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-  
НИЙТЛЭЛИЙН ДУРСГАЛТ БИЧИГ МӨН” СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН  
ТУХАЙ**

М.Наранчимэг\*

\* Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн Олон улс судлал, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D)

**Түлхүүр үг:** Нийтлэл, утга зохиол, дурсгалт бичиг, зан заншил, ёс суртахуун мэдээлэл, уламжлал, хандлага

**М**УСГЗ, доктор, профессор, сэтгүүл зүй судлаач Лэгсрэн овогт Тугалхүүгийн Баасансүрэнгийн “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” хэмээх сэтгүүл зүй судлалын цуврал 5 боть, /сүүлд нэг боть нэмж бичсэн/ зохиолд задлан шинжлэл хийж, “Доктор, профессор Т.Баасансүрэнгийн сэтгүүл зүйн судалгааны бүтээлийн зарим онцлог” сэдвээр МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимээс эрхлэн гаргадаг мэргэжлийн “Сэтгүүл зүй” эрдэм шинжилгээний бичгийн №18 /479/-д 2017 онд өгүүлэл бичиж хэвлүүлснээ мартаагүй байна.

Түүний туурвисан “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” нэрийн дор цувралаар сэтгүүл зүйн томоохон хэмжээний судалгааны бүтээлүүд нь Монголын сэтгүүл зүйн онол, практикийг хөгжүүлэхэд тодорхой түлхэц болсон билээ. 2014 онд туурвиж, 2017 онд нэг бүлэг нэмж уншигчдадаа өргөн барьсан “Монголын нууц товчоо” нийтлэлийн дурсгалт бичиг мөн” ном нь шинжлэх

ухаанд шинэ үг хэлсэн онцгой бүтээл болсон юм.

“Доктор, профессор Т.Баасансүрэнгийн сэтгүүл зүйн судалгааны бүтээлийн зарим онцлог” эрдэм шинжилгээний өгүүллээрээ Т.Баасансүрэн бол Монголын сэтгүүл зүйн шүүмж судлалыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан судлаач мөн болохыг тодотгохыг зорилгоо болгож байсан бол энэ удаа эрдэмтэн, судлаач багшийнхаа сэтгүүл зүй судлалд цоо шинэ өнцөг, мөр гаргасан нэгэн бүтээлд мэргэжлийн үүднээс задлан шинжлэл хийж, түүний онцлогийг гаргахыг зорив.

“Монголын нууц товчоо” нийтлэлийн дурсгалт бичиг мөн”/ “Монголын нууц товчоо”-н дахь баримтын мөрөөр мөшгөхүй/ зохиол нь зургаан бүлэгт хувааж, маш өргөн дэлгэр мэдээлэл, баримт, судалгааг багтаажээ. Судлаачаас асар их хөдөлмөр, бүтээлч чанарыг шаардсан уг судалгаа сэтгүүл зүйн судлалд үнэ цэнтэй хувь нэмэр оруулсан болох нь тус бүтээлийг уншихад аяндаа мэдрэгдэнэ.

Тус номын эхэнд монголын нэртэй эрдэмтэд бүтээлийн талаар өөрсдийн үнэлэлт дүгнэлтийг хийж, сүүн цацалтай үгээ хэлжээ. Академич Т.Дорж

“Шинжлэл судлалд шинэ үг хэлсэн бүтээл” гарчигтайгаар тус номын өвөрмөц дүр төрхийг товойлгон гаргаж, “Монголын нууц товчоо”-г шинэ өнцгөөс олж хараад нийтлэлийн дурсгалт бичиг болох талаар өөрийн саналыг дэвшүүлж, түүнийгээ түүхэн үйл явдал мөнийг баталгаажуулсан олон арван эрдэмтдийн нотолгоонд суурилан өөрийн дүгнэлтээр лавшруулан, баримтын мөрөөр уйгагүй мөшгөсөн эрэл хайгуулын судалгааны үр дүнд эл хөлгөн судрыг Монголын нийтлэл бичиглэлийн охь дээж мөн гэсэн дүгнэлтэд хүрсэн нь сэтгүүл зүйн шинжлэлд шинэ үг хэлсэн бүтээл хэмээн үнэлсэн байна. Түүх судлаач, МСНЭ-ийн уран бүтээлийн болон “Ц.Балдорж сан”-гийн шилдэг бичлэгийн шагналт, сэтгүүлч Б.Номинчимэд “Монголын нууц товчоо” хэмээх дундаршгүй эрдэнэсийн уурхайд урьд өмнө нь тэр бүр хүний яваагүй мөрөөр замнан, шан татаж буй хүн бол зохиолч, сэтгүүлч номын багш Т.Баасансүрэн мөн гэж үнэлсэн байна. Номын нэгдүгээр бүлэг “Монголын нууц товчоо”-н дахь баримтын мөрөөр мөшгөхүй гарчигтай. Энэ бүлэг “Монголын нууц товчоо” хэмээх хөлгөн судрын судлал, шинжлэлийн ажил хэзээ хаанаас эхтэй болохыг олон эх сурвалжаар тодруулан гаргаж, тус бүтээл дэх бодит хүмүүс, газар нутаг, улс орон, хот балгадын нэрс, Чингис хааны цэргийн урлаг, дипломат бодлогын талаарх баримтыг хөөн, нягталж, түүний мөрөөр олон судалгааны ном, зохиолд тулгуурлан бичиж өөрийн дүгнэлтийг өгсөн байна.

XX зууны эхэн үеийн монголчуудын эрдэм судлалын эцэг гэгддэг, монголын шинэ цагийн сэтгүүл зүйг үндэслэгч Жамсраны Цэвээн аругай эхийг Хятадаас авчирч, Бавуудайн Цэнд гүнтэн 1917 онд тухайн цагийн монгол хэл рүү

утгачлан хөрвүүлж, оршил бичиг хавсаргажээ. Уг бичмэл эх одоо ОХУ-ын Санкт Петербург дэхь Дорно дахины судлалын хүрээлэнгийн гар бичмэлийн тасагт байгаа аж. Энэхүү бүтээлийг туурвигч доктор Т.Баасансүрэн “Монголын нууц товчоо”-ны уг сурвалж эхийг хайх явцдаа Ж.Цэвээн эрдэмтний олж мэдсэн, зохиол бүтээл, сонин хэвлэлд бичиж үлдээсэн олон хууч яриа, захидал зэрэг маш содон сонирхолтой түүхүүд номдоо оруулсан байна.

Тэрээр мөн уг хөлгөн судрын нууцад нэвтэрч олон арван бүтээлийг туурвисан эрдэмтдийн ном, судалгааг онцолсон байна. Тухайлбал П.И.Кафаров, Хэниш, С.А.Козин, Б.Я.Владимирцов, Сайшаал, Баяр, Эренжан, Хара-даваа, Пауль Рачневский, Л.Н.Гумилев, Ш.Озава зэрэг олон эрдэмтэн судлаачдыг дурджээ.

“Монголын нууц товчоо”-нд гарч буй бодит хүмүүсийн тухай нийт 66 хуудсанд багтааж өгүүлсэн байна. Ингэхдээ академич Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлгээр /1976он/ бодит хүн давхардсан тоогоор 3275, академич Д.Цэрэнсодном нарын /2004/ шинэчлэн найруулсан орчуулгаар энэ тоо 3035 байна гэжээ. Энэхүү бодит хүмүүсийн тооны зөрүүг академич Ц.Дамдинсүрэн Рашид Дины “Судрын чуулган”, Лу “Алтан товч”, Чингисийн Цэдэг” зэрэг ном зохиолоос зарим үг өгүүлбэрийг нөхвөрлөж оруулсантай холбоотой байх хэмээн тайлбар зүүжээ.

Академич С.Нарангэрэл “Чингис хаанд түүний өвөг дээдсийн ёс суртахуун удамшсан гээд тэрхүү эрхэм чанар генд нь байна гэж судалгааныхаа үр дүнд баталсан байна. Зохиогч дээрх бүтээлээс эш татаж, Чингис хаан, түүний нөхдийн урвашгүй үнэнч байдал, эд агуурсад үл сувдаглах, атаа жөтөө эс

өвөртлөх, дайснаа ч үнэлж цэгнэх чадвар нь бодитой үр дүнд хүргэсэн болохыг батлах тодорхой жишээг энд дурджээ. Төрийн үйл хэрэгт тус хүргэсэн итгэлт нөхдийн ач тус, иргэд төр хоорондын гүн бат итгэл, итгэлцэл дээр Эзэнт гүрэн оршин тогтсоны баталгаа энэ болох юм. Эл номын олзуурхууштай өөр нэг судалгаа бол Д.Пүрэвдоржийн “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл” номоос “Монголын нууц товчоо” түүхэн сурвалжийн гол эзэн Тэмүүжин Чингис хааны мэндэлсэн болоод өөд болсон, гэрлэсэн, Хамаг Монгол Улсын хаанд өргөмжилсөн он цаг, үйл явдлын талаарх хорин дөрвөн номын эх бичвэр, түүхийн сурвалж бичгийг харьцуулсан судалгааг оруулж өгсөн нь олон чухал мэдээллийг үнэн бодитой сурвалжуудаас олж мэдэж, судалгаа шинжилгээнд ашиглаж болох боломжийг олгожээ.

“Монголын нууц товчоон 383 хүний түүхэн товчис” номыг тэрлэгч МУСГЗ, зохиолч, сэтгүүлч, түүх судлаач Ш.Цэен-Ойдовын хамтын бүтээлээс судлаач өөрийн номдоо А-Я хүртэлх цагаан толгойн үсгийн дарааллаар хүснэгтээр үзүүлж, уг номын хэддүгээр хуудсанд тухайн хүний талаарх баримт мэдээлэл байгааг зааж, зарим нэг хүний намтар, түүхийг дэлгэрүүлэн жишээ болгон оруулсан нь бодит хүмүүсийн амьдралын түүхийг батлан харуулах бас нэг үндэс болжээ. Энэ нь “Монголын нууц товчоо” хөлгөн судрыг улам үнэ цэнтэй, бодит үйл явдал, үзэгдлийн гэрч, эх сурвалж болохыг улам лавшруулж байгаа баримт гэж үзэхэд хүргэж байгаа юм.

**Д**октор Т.Баасансүрэн “Монголын нууц товчоо”-нд гардаг түүхт нутгууд Монгол орны нутаг дэвсгэр дээр уугуул нэр нь хэвээр өнөөг хүртэл дамжин ирснийг тэмдэглээд, академич Х.Пэрлээгийн “Нууц товчоонд гардаг

газар усны зарим нэрийг хайж олсон нь” хэмээх 1958 онд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний товхимлыг онцолжээ. Тэрээр нууц товчоонд гардаг газар усны түүхэн нэрийн бараг далаад хувийг олж мэдсэн байна. Түүний номд хөлгөн сударт бичигдсэн 132 бодит газар нутаг, уул усны нэр тодорхой болж, уртраг, өргөрөгтэй нь тэмдэглэн, аль нутагт хаана байгааг тайлбарласан аж. Энэ нь “Монголын нууц товчоо”-н дахь бодит газар ус, түүхт нутгийг анх удаа шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, олон түмэнд хүргэсэн үнэт мэдээлэл мөн хэмээн доктор Т.Баасансүрэн үзэж, өөрийн бүтээлдээ эш татан оруулжээ. Тэрээр цааш нь судлаач доктор Х.Шагдарын “Чингис хааны байлдааны цадиг, 1179-1206” номдоо оруулсан “Монголын нууц товчоо”-нд гардаг дайн тулаан болсон 67 газар усны нэрийн тайлбарыг, Чорос овогт Өөлдийн Бавуугийн “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэсэн түүхт зарим нутгууд” хэмээх 2005 онд бичсэн номыг судлан шинжилж, доктор Т.Баасансүрэн дээрх эрдэмтдийн “Монголын нууц товчоо”-н дахь түүхт газар нутгууд, уул усны талаарх судалгааг хооронд нь харьцуулан жиших замаар өөрийн дүгнэлтийг хийсэн байна. Тухайлбал “Түнхэлэг горхи” хэмээх нэгэн тунгалаг уст горхи Монголд үнэхээр байжээ. Тэр нь Чингис хааны түүхтэй аргагүй холбоотой ариун газар усан мөн гэсэн итгэл үнэмшлийг бидэнд өгч байна.<sup>1</sup> “Монголын нууц товчоо”-г зохиогч Түнхэлэг горхийн нэрийг бүтээлдээ олонтаа дурдсан байдаг. Х.Пэрлээ, Ө.Бавуу судлаачдын “Түнхэлэг горхи” хаана байдаг талаарх таамаглал хараахан зөрж байгаа ч цаг улирлын аясаар газар дэлхий хувьсан өөрчлөгдөж, дэлхийн дулааралтай холбоотой нэг горхи, гол төдийгүй нэг хэсэг нуур цөөрөм, мөрөн гол алга болж

байгааг харгалзан үзэх учиртай байх хэмээн тайлбар хийсэн байна. “Монголын нууц товчоо”-нд гардаг газар усны нэрийг тодорхойлох гэж эрдэмтэд судлаачид ямар их хүч, цаг хугацаа зарцуулж, чимхлүүр нарийн хөдөлмөр зориулж, үгүйсгэж няцаахын аргагүй тооцоо судалгаа хийж, баримтаар баталгаажуулдаг болохыг судалгааны явцад илрүүлжээ. “Монголын нууц товчоо”-нд Чингис хааны цэргийн урлаг, дипломат бодлогын талаарх бодит баримтыг эл бүтээлдээ оруулахдаа Чингис хаан, түүний үнэнч шадар туслах, анд нөхдийн итгэл зүтгэл, шударга үнэнч байдал, нэг зорилгын төлөө тууштай зоригтой тэвчээртэй зүтгэж, нэгдэж чаддаг байсныг “Монголын нууц товчоо”-н дахь олон арван баримтаар жишээлжээ. Чингисийн армийн чанд зохион байгуулалт, хөдөлбөргүй мөрддөг дүрэм журамд цэргийн урлагийн үндсэн амин сүнс оршиж байсан гэж олон судлаачид үзсэн байдаг байна.

Доктор Т.Баасансүрэн “Монголын нууц товчоо”-ны 203, 209, 235, 246, 239 дүгээр зүйлийг жишээ болгон авч, Чингис хааны цэрэг байлдааны үеийн урлаг, дипломат харилцааны талаар баримталж байсан бодлогыг тодруулан баримтаар нотлон, Тухайлбал “Монголын нууц товчоо”-ны 235 дугаар зүйлд “Хубилай ноёныг Харлагуудад мордуулав. Харлагийн Арслан хан, Хубилайд элсэн ирсэнд Арслан ханыг авчирч Чингис хаанд уулзуулав. Арсланг байлдсангүй дагав гэж сайшаан соёрхож, охиноо өгье гэж зарлиг болов” хэмээсэн нь дайн байлдааныг дипломат аргаар шийдэж байсны нэгээхэн жишээ юм гэжээ. Энэ мэт олон арван жишээг “Монголын нууц товчоо”-н дахь баримтыг өгүүлсний сацуу Чингис хааны цэрэг байлдааны тактик, дипломат

харилцааг судалдаг эрдэмтдийн ном бүтээлээр баяжуулжээ.

Сэтгүүл зүй судлаач, доктор Т.Баасансүрэн “Монголын нууц товчоо”-ны үнэн бодит түүхийг судлан шинжлэхдээ уг түүхэн сурвалж бичгийг өөрийн мэргэжлийн шинжлэх ухааны үүднээс шинжлэн судалсан эрдэмтэн мэргэдийн олон арван бүтээлд дүн шинжилгээ хийх замаар, баримтыг нягтлан үзэж, харьцуулан жишиж, хураангуйлан товчоолж, түүхэн эх сурвалжид нэр нь дурдагдсан 3257/3035 хүний бодит дүр, түүхт газар нутаг, уул усны нэрсийг тодруулах замаар, Чингис хааны цэргийн урлагийн тактик, гадаад, дотоод улс оронд баримталж байсан дипломат харилцаанд тулгуурлан, баримт нотолгоонд суурилан, түүхэн чухал үйл явдал үзэгдлийг тодруулан гаргаж ирсэнд энэхүү бүлгийн үнэ цэн, ач холбогдол оршиж байна гэж үзэв.

Хоёрдугаар бүлэг. “Монголын нууц товчоо”-г хуучин монгол хэлээс орчин цагийн монгол хэл рүү хөрвүүлсэн хоёр хувилбарыг харьцуулан жишиж шинжихүй хэмээх гарчигтай.

**Н**омын эхэнд хүн төрөлхтний түүхэнд тэмдэглэгдэн үлдээсэн Грекийн “Илиада Одиссей”, Оросын “Игорын хорооны тууж”-аас эхлээд дэлхийн улс гүрнүүдээс ард түмнүүдийн соёлын өвд бүртгэгдсэн гайхамшигт бүтээлүүдтэй эн зэрэгцэх “Монголын нууц товчоо”-г хуучин монгол хэлээс өнөөгийн монгол хэлэнд хөрвүүлэн буулгасан академич Ц.Дамдинсүрэн, Д.Цэрэнсодном нарын орчуулгыг сонирхолтой хэлбэрээр харьцуулан жишиж хүснэгтээр харуулсан байна. “Монголын нууц товчоо”-ны 105 дугаар зүйлийг хуучин монгол бичгээр галиглаж буулгасныг жишээлэн авч, Цэнд гүн, эрдэмтэн Ц.Дамдинсүрэн, Д.Цэрэнсодном нарын орчин үеийн хэл

рүү хөрвүүлсэн байдлыг харьцуулжээ. Эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн орчуулга арван мөр шүлгээс бүрдсэн бол академич Д.Цэрэнсодном нарынх долоон мөр байна. Үндсэн эх зохиол долоон мөр шүлгээс бүрджээ. Харин Цэнд гүн 18 үгээс бүрдсэн асуух өгүүлбэрээр орчуулжээ. Эндээс ажиглахад Монгол түмний бахархалт түүх болсон “Монголын нууц товчоо”-г өнөөгийн бидэнд өвлүүлэн, үлдээх зорилготой гурван эрдэмтний энэхүү бүтээлийн хөрвүүлэгт хандсан хандлага, баримталсан зарчим нь өөр өөр болохыг ганцхан жишээнээс харахад ойлгогдож байна. Академич Ц.Дамдинсүрэн “Монголын нууц товчоо”-ны үйл явдлыг өнөөгийн уншигч түмэнд зориулж, уран сайхны хэллэгийг түлхүү ашиглаж хөрвүүлсэн бол, академич Д.Цэрэнсодном нар хуучин эхийг тэр чигт нь баримтлан өнөөгийн бичгийн хэллэгээр орчуулсан нь илт харагдаж байна. Цэнд гүн Тэмүүжиний Жамухад шүлэглэн хэлсэн үгийг хүүрнэн өгүүлэх хэлбэрээр хөрвүүлэн буулгажээ.

Сэтгүүл зүй судлаач, доктор Т.Баасансүрэн энэхүү бүлгийг бүхэлд нь хоёр

академичийн нууц товчооны хөрвүүлгийг харьцуулах замаар орчуул-гын найруулгад өнөөгийн хэлний бүтэц онцлог, нийтлэлийн онолын үүднээс шинжлэн судалж, “Алдаа ташаарлыг тольдож арилгахыг чармайсан нь”, “Сайхан үг хэллэгээр сайжруулахыг чармайсан нь”, адилхан хэмжээнд дүйлгэж махчлан хөрвүүлсэн зарим зүйлийн тухай цухасхан өгүүлэх нь” гэсэн дэд гарчгийн дор олон баримтыг жишээлэн эш татаж, өөрийн үзэл санааг илэрхийлэн, харьцуулан судлах аргаар судалгааны үр дүнг гаргаж, өөрийн дүгнэлтийг өгчээ.

**Т**ухайлбал “Сайхан үг хэллэгээр сайжруулахыг чармайсан нь” гарчгийн дор судлаач өгүүлэхдээ Д.Цэрэнсодном нарын орчуулга нь оновчтой үгийг сонгож яруу сайхан болгож чанаржуулахыг зорьсон үг, өгүүлбэр, бадаг мөр байна гээд академич Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэгтэй жишин харьцуулжээ<sup>2</sup>. Илүү ойлгомжтой болгох үүднээс хэдэн жишээг онцлон хүснэгтээр харуулъя.

№	Академич Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг	Академич Д.Цэрэнсодном нарын хөрвүүлэг
1	“Монголын нууц товчоо”-ны 19 дүгээр зүйлд: хонины хатсан мах	хонины хөншилмөл /хуршмал/ мах
2	“Монголын нууц товчоо”-ны 24-р зүйл: үхвэл үхье, амьдарвал амьдаръя	үхвээс үхсүгэй, байваас байсугай
3	“Монголын нууц товчоо”-ны 90-р зүйлд: тарвагануудыг дааж ядтал ачиж	тарвага нугасалзтал ачиж
4	“Монголын нууц товчоо”-ны 98-р зүйлд: газар дэлбэрэх мэт чимээ гарч морины төвөргөөн сонсогдоно	газар доргилж, төвөргөөн сонстоно
5	“Монголын нууц товчоо”-ны 184-р зүйлд: “Өмнө хойно нь орж явахад”, Гуяны угийг хойш унатал харважээ	“Урдуур хойгуур нь хөрөөдөн явахуйд”, Гуяны угийг суутал харважээ

“Арай дордуулж муутгасан байж болзошгүй зарим зүйлийн тухай” гарчгийн дор эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн “Монголын нууц товчоо”-ны хөрвүүлгийг дордуулсан байж болох үг, өгүүлбэрийг

сонгон авч харьцуулан хүснэгтээр харуулж тайлбар хийсэн байна. Тэрээр эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлсэн Найманы Таян ханд их эзэн Чингис хааны шадар туслах, эрэлхэг баатруу-

дын талаар Жамухын өгүүлсэн хэсгүүдийг “Монголын нууц товчоо”-ны “Шижиртсэн гэрэлт шигтгээ” хэмээн тодорхойлоод, харин академич Д.Цэрэнсодном нарын орчуулгыг хуучны хэллэгт тулгуурлан хөрвүүлсэн нь

ончтой, дүрслэлтэй сонин үг хэллэг цөөнгүй тааралдаж байгаа хэдий ч ур хийцийн хувьд үнэхээр дордуулсан гэж үзэж, түүнийгээ харьцуулсан жишээгээр тодотгон харуулжээ. Хэд хэдэн жишээ татаж хүснэгтээр харуулъя.

№	Академич Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг	Академич Д.Цэрэнсодном нарын хөрвүүлэг
1	<b>“Монголын нууц товчоо”-ны 57-р зүйлд:</b> Хавирга газрыг халцартал, өвдөг газрыг өлтөртөл дэвхцэн бүжиглэж хуримлав	Хавиргандаа хуулга болтол өвдгөндөө өвчин ортол дэвсэв \бүжиглэв\
2	<b>“Монголын нууц товчоо”-ны 74-р зүйлд:</b> Оюунтай төрсөн Өүлэн эх Оёдолт дээлийг огшуулан өмсөж Оготор хормойг шуун бүсэлж Онон мөрнийг өгсөж уруудаж Олирс мойлыг түүж явж Өчүүхэн хөвүүдээ хайрлан тэжээж Өдөр шөнийг аргацаан өнгөрүүлэв	Өгэлүн үжин мэргэн төрж Өчүүхэн хөвүүдээ тэжээхээр Өхийтөл богтолж, огдойтол бүсэлж Онон мөрний өөд уруу гүйж Олирс, мойлс түүж Өдөр шөнө хооллон тэжээв
3	<b>“Монголын нууц товчоо”-ны 79-р зүйлд:</b> Хурганы үс гуужив, төлөгний бие төлжив Өэлүний хөвүүд тэнхрэв гэж довтлохоор ирэв	Хулхи нь гуужиж, шүлс нь сэвэрчихлээ хэмээн довтлон ирэв
4	<b>“Монголын нууц товчоо”-ны 103-р зүйлд:</b> Солонго мэт сонсох соргог Хуагчины Сонорын хүчээр Үен мэт үзэх үнэнч Хуагчины Үзсэний ачаар \аюулт дайснаас амжин дутааж\ Бүтэн биеэ бүгэн нуугдаж Бүдэг замыг мөрдөн дагаж Бугын мөрийг мөшгөн хөөж Бургасан гэрт буруулан нуугдаж Бурхан халдунд амь хоргодов... ..хэмээн бүсээ хүзүүнд эрих мэт өлгөж, малгайгаа гарт сэгэлдэрч, гараар өвчүүгээ дарж, наран өөд хандаж, Бурхан халдунд есөнтээ сөгдөж, өчил өчин сацал сацав.	Хоогчин эхийг солонго болж сонссоны ачаар Үнэ болж үзсэний тул Бүтэн биеэ буруулан бухияа морьт болж Бугын жим дагаж бургасан гэр гэрлэж Бурхан дээр гарлаа Бурхан халдунаа бөөсний төдий амиа Булзуулав. би... хэмээн наран өөд хандаж, бүсээ хүзүүндээ эрихлэж, малгайгаа гартаа сэгэлдэргэлж, гараа өвчүүндээ дарж, наран зүг есөнтөө сөгдөж, сацал сацаж, өчил өгөв.
5	<b>“Монголын нууц товчоо”-ны 194-р зүйлд:</b> Монголчууд хаанаас олон байх вэ? Монголын олонхи, Жамухыг дагаж энд бидэнд байна. Жирэмсэн эмийн шээх газраас хол яваагүй Жижиг тугалын бэлчих газраас гарч үзээгүй Эм Таян зүрх алдаж энэ үгийг хэлжээ гэж Эцэг Таян ханыг элдвээр дайран доромжилж Элч хүнээ илгээв.	Аанай бас ийн Эм Таян зүрх ядрахдаа энэ үгийг өгүүлжээ Монголын олон хаанаас иржихүй. Монголын олонх Жамухатай энд бидэнд буй. Хүнд эмийн шээх газар эс гарсан Хүрдний тугалын бэлчээрт эс хүрсэн Эм Таян зүрх алдан эс зориглож Эдгээр үгсийг өгүүлж илгээжээ.
6	<b>“Монголын нууц товчоо”-ны 249-р зүйлд:</b> Тангуд улсын эзэн Бурханы өчилд, Байсан газартаа байран нутагладаг Шавар хотдоо шавалдан суудаг Хүмүүс тул хурдан аянд түргэн хөдөлж чадахгүй. Хурц дайнд даруй мордож амжихгүй.	Хүч өгөхөд нунж нутагтан Нүдсэн балгастан буй за. Хурдан аянд аялахад Хурц дайн дайралдахад Хурдан аянд гүйцэж ядмуу, зэ. Хурц дайнд дайралдаж ядмуу зэ, бид.

Орчин цагийн монгол хэлэнд “Монголын нууц товчоо”-г хөрвүүлсэн эрдэмтдийн бүтээлийг ингэж няхуур хандаж, алдаа оноог дэнслэн шүүж, харьцуулалт хийж судалсан судалгаа бараг байхгүй болов уу.

Тэрээр хоёр хөрвүүлгийг харьцуулахаас гадна, академич Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлгийг онцгойлон авч үзэж, зөвхөн орчуулах зорилго тавьсангүй, монгол хэл дээрх үндсэн эхээс үрэгдэж гээгдсэн зүйл байж болзошгүйг эрж хайж, үүний үрээр нэлээд зүйлийг бусад түүхийн баримтаас цуглуулан, нууц товчоонд нөхвөрлөн оруулсныг олзуурхан дурдсан юм. “Алтан товч” зэрэг зарим зохиолоос эшилсэн хийгээд Ц.Дамдинсүрэн гуайн уран сайхны орчуулгын тухай цухасхан өгүүлэхийн учир” хэмээх гарчгийн дор академичийн “Монголын нууц товчоо”-г хөрвүүлэхдээ гээгдсэн байж болох үг хэллэг, өгүүлбэрийг олон ном зохиол, бусад орчуулга, сийрүүлгээс цуглуулж, ашигласан байдлыг судлаач доктор Т.Баасансүрэн өндрөөр үнэлж буйгаа илэрхийлжээ. Тэрээр нууц товчооны хятад үсгийн эхийг Цэнд гүнгийн орчуулга, Лу “Алтан товч”, “Чингисийн цэдэг”, Рашид Эддиний “Монголын түүх” зэрэгтэй харьцуулан судалж, нөр их хөдөлмөр, цаг хугацаа, хүчин чармайлт гаргасны илэрхийлэл энэ мөн гэсэн байна. Доктор Т.Баасансүрэн “Чингисийн Цэдэг” болон Лу “Алтан товч” зэргээс “Монголын нууц товчоо”-нд нөхөж оруулсан шүлгийн бадаг мөр, үг, өгүүлбэрээс энд тусгайлан жишээ татаж өөрийн судалгааны номдоо оруулжээ. Тухайлбал 190-р зүйлд Рашид Эддиний “Монголын түүх”-ээс, 86-р зүйлд Лу “Алтан товч”-оос “Дөнгөт хүн хаа холдох билээ, сэтгэлээ ханатал эр” зэрэг үгийг авч зохих байранд нь оруулжээ. Эдгээр нь “Монголын нууц

товчоо”-ны агуулгыг дэлгэрүүлэн үйл явдлын үнэнийг улам баталгаажуулсан ач холбогдолтой хэмээн зохиогч үзсэн байна.

“Монголын нууц товчоо” XII-XIII зууны үеийн Монголын нийгмийн түүхэн, үнэн бодит үйл явдлыг уран нийтлэлийн хэлээр дүрсэлсэн зохиол яах аргагүй мөн юм. Тиймээс “Монголын нууц товчоо”-г баримтат зохиол уран нийтлэл мөн гэж үзэж, зөвхөн монголын хуучны уран зохиолын төдийгүй баримтат нийтлэлийн дээж бичиг гэж үзвэл зохино гэж өөрийн саналаа дэвшүүлжээ.

Гуравдугаар бүлэг. ““Монголын нууц товчоо”-г хөрвүүлсэн хоёр хувилбарт хийсэн зарим ажиглалтыг Цэнд гүнгийн анхдагч орчуулга, Ш.Чоймаагийн эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэгтэй тулган нягталж сурвалжлахуй” хэмээх гарчигтай.

Энэхүү бүлэг монгол хэлээр хятад үсгээр хадмалж бичсэн “Монголын нууц товчоо”-г Бодлогот баатар гүн Цэндийн анх удаа өөрийн хэл рүү орчуулсан эхийг эрдэмтэн доктор Ш.Чоймаа, академич Ц.Дамдинсүрэн, Д.Цэрэнсодном нарын хөрвүүлэгтэй тулгаж, анхны эхээс зөрсөн болон утга агуулга нь хувирч өөрчлөгдсөн үг хэллэг байгаа эсэхийг хянан харгалдуулж задлан шинжлэл хийж, өөрийн санал дүгнэлтийг гаргаснаараа, өмнөх хөрвүүлсэн хоёр хувилбарыг гурав, дөрөв дэх хөрвүүлэгтэй дахин харьцуулан шинжилснээрээ өвөрмөц судалгааны ажил болсон байна.

Доктор Т.Баасансүрэнгийн судалгааг илүү ойлгомжтой харуулахыг зорьж, дөрвөн эрдэмтний хөрвүүлгийг харьцуулсан жишээг хүснэгтээр харуулъя.

№	Цэнд гүнгийн анхдагч хөрвүүлэг	Академич Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг	Академич Д.Цэрэнсодном нарын хөрвүүлэг	Доктор Ш.Чоймаагийн хөрвүүлэг
1	“Монголын нууц товчоо”-ны 28-р зүйлд: Түйлэнгэртээс Түнхлэг горхи руу бүлэг иргэн нүүж ирэвээ	“Дүйрэн уулын гэх нэр дурдаагүй байна	“Дүйрэн уулын араас Түнхэлэг горхин руу нэгэн Бөлөг иргэн нүүж ирэв	“Дүйрэн уулын Хэрүүгээс гэжээ
2	“Монголын нууц товчоо”-ны 41-р зүйлд: Хөвүүн нь манан мэт төрвөө	Хөвүүн нь манан мэт \олон\ төрөв	Хөвүүн нь мэнэ мэт \олон үр зулзага гаргадаг мэлхий\ гэж тайлбарлажээ	Хөвүүн нь мэнэ мэт
3	“Монголын нууц товчоо”-ны 129-р зүйлд: “Ононы Зэлинэд оргов” бид гэж Харихдаа Чинсун хүн далан тогоотой буцалгаж,...	“Ононы зээрэн хавцалд тэднийг бид шургуулав” гэж буцахдаа чинос овгийн залуусыг далан тогоонд буцалгаж,..	“Бид Ононы Жэрэнэд хоргоов” хэмээн харихдаа Чиносын хөвүүдийг Далан тогоодод буцалгаж \буцаалгаж?!\,.	далан тогоонд буцалгаж,..
4	“Монголын нууц товчоо”-ны 278-р зүйлд: Зарлигийг сонсоод болон хишигтэн хишиг хулсу зарлигийн ёсоор эрүүлбэ. Энэ зарлиг хишигтнийг эс Сонгосу, хишгүүдийн өтгөс Алдалтан болтугай, бас гадаадсу мянгатын ноёдоос миний хишигтэн дээр буй заа. Үүдэнд гэрийн хорчи хэвтүүл байтугай. Ордын хойнын Урьдын хэвтүүл мухултугай... үүдэн цаад хэвтүүл үүдчин байтугай.	Энэ өгүүлбэр хөрвүүлэгт орхигдсон	Зарлиг дуулсан хэшигтэн хэшиг огоорвоос, зарлиг ёсоор алдалтан болгоё, гаднах зууд, аравдын ноёдоос миний хэшигтний хөтөч дээр буй за...үүдэнд гэрийн орчим хэвтүүл байтугай! Ордын хойгуур урдуур хэвтүүл мухарлан үзтүгэй!	Үүдэнд гэрийн орчин хэвтүүл байтугай. Ордын хойнуун урдуун хэвтүүл мухарлатугай.
5	“Монголын нууц товчоо”-ны 24-р зүйлд: Бодончар урагт эс тооцогдож атал юун гэж гол дайрт оготор сүүлт орогчин хулыг унаж “үхбээс үхсүгэй, агаасаа Агасугай” гэж Онон мөрөн рүү зочиж тальбиба гэжээ.	Бодончар урагт эс тоологдох атал, энд юу хийж сууна гээд гол дайрт, годил сүүлт орог морио унаж “үхвэл үхье, амьдарвал амьдаръя” гэж Онон мөрөн рүү зорьж одов гэжээ.	Бодончар урагт эс Тооцогдож, “энд юу хийж сууна” хэмээгээд гол дайрт годил сүүлт орог шунхлыг унаж “ үхвээс үхсүгэй, байваас байсугай гэжээ.	“Аваас инү асугай” гэж эртний хэллэгээр нь бичээд \байваас байсугай, амьдарваас амьдарсугай\ гэж тайлбар бичжээ.
6	“Монголын нууц товчоо”-ны 90-р зүйлд: “Үдэш наран шингэсний хойно тарж оготор хонгорт тарвага ачиж няхалзтал явган хөтөлж ирэв”	“Үдэш нар шингэсний хойно оготор хонгор мориндоо тарвагануудыг дааж ядтал ачиж явган хөтөлж ирэв”	“Үдэш нар шингэсний хойно Бэлгүдэй оготор дарги хонгорт тарвага нугасзтал ачиж явган хөтөлж ирэв”	“Үдэш наран шингэсний хойно тарж оготор хонгорт тарвага ачиж нягсгалзтал явган хөтөлж ирэв”
7	“Монголын нууц товчоо”-ны 98-р зүйлд: Хэрлэн мөрний тэргүүн Боржи Эрэгт бууж бүхийд нэгэн манагар эрт гэрэл шаран өдөр гийх бүхийд Өэлүн эхийн гэр дотор хөдөлхүйн Хутагачин эмгэн босож өгүүлрүүн: эх эх өттөр бос газар дэрбэлмүй тобурайн сонсогдмуй. Аймшигтан Тайчууд айсуй ахунаа. Эх өнөөдөр бос гэв.	Хэрлэн мөрний эх Бүрги Эрэгт нутаглаж байтал, нэгэн өглөө эрт үүр цайж байхад Өэлүн эхийн гэрт зарцлагдах Хуагчин эмгэн босч үгүүлрүүн: эх эх үтэр бос. Газар дэлбэрэх мэт чимээ гарч морины төвөргөөн сонсогдоно. Аймшигт Тайчууд айсуй биз. Эх даруй бос.	Хэрлэн мөрний эх Бүрги эрэгт нутаглан бүхүйд, нэгэн өглөө эрт гэрэлт шар өдөр гийж бүхүйд Өгэлүн эхийн \гэр дотор Хөдлөх\ Хоогчин эмгэн босч өгүүлрүүн: эх эх үтэр бос газар доргилж, төвөргөөн сонсоно. Залхамшигт Тайчууд айсуй буюу? эх үтэр бос.	“газар дэрвэлмүй, төвөргөөн Сонсдмуй” гэжээ.



Сэтгүүл зүй судлаач, доктор Т.Баасансүрэн “Монголын нууц товчоо”-г дээрх эрдэмтэд хуучин монгол бичгээс хөрвүүлсэн эрдэмтдийн бүтээлд маш хянамгай, няхуур хандсан нь энэ бүлгийн харьцуулалтаас эл харагдаж байна. Энэ бүхнийг бүгдийг харуулах боломж цаг бага тул цөөхөн хэдийг жишээ болгон авлаа. “Монголын нууц товчоо”-г хөрвүүлсэн хоёр хувилбарт хийсэн ажиглалт, Цэнд гүнгийн анхдагч орчуулга, Ш.Чоймаагийн эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэгтэй тулган нягталсны үр дүнд дээрх эрдэмтэд уг хөрвүүлгийг хийхдээ ямар зарчим, арга барилыг баримталсныг, ямар үг хэллэг, утга агуулгын зөрөө гарч байгааг нягталжээ. Эртний үг хэллэгээс хөрвүүлсэн “Монголын нууц товчоо”-ны орчуулгыг ажиглахад дээрх судлаач, эрдэмтдийн орчуулгаас цөөнгүй үгийн утга зөрөх, агуулга өөрчлөгдсөн байдал харагдаж байгаа нь түүхийн урт удаан хөгжлийн явцад үг гээгдэх, утга өөрчлөгдөх үйл явц илэрч байдгийн нэг тод жишээг давхар батлан харуулж байна.

**Д**өрөвдүгээр бүлэг. Хүн төрөлхтний хөгжилд Монголын эзэнт гүрэн, “Мянганы суут хүн” Чингис хааны гүйцэтгэсэн үүрэг, түүхэнд түүний эзлэх байр суурь / “Их Монгол Улс” номын үнэ цэнэ/ гарчигтай.

Эсгий туургатнуудын түүхэн баярыг даян дэлхийн хамтын нийгэмлэгийн баяр болгож тэмдэглэсэн үйл явдалд зориулж, Монгол Улсын 3 дахь Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр санаачлан 2007 онд “Их Монгол Улс” номыг бүтээжээ. Номын агуулга төрт ёсны олон зуун мянган жилийн уламжлалтай монгол түмний дэлхийн соёл иргэншлийн сан хөмрөгт оруулсан хувь нэмэр, эзэн Чингис хаан хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд ямар үүрэг гүйцэтгэж,

яаж нөлөөлөв гэдэгт тавиад орны Эзэн хаан, Ерөнхийлөгч, төр засгийн тэргүүнүүд болон шашин соёлын нэрт зүтгэлтнүүдийн үнэлэлт, дүгнэлт сэтгэгдлээс бүрдсэн байна. Судлаач, доктор Т.Баасансүрэн Чингис хаан, түүний байгуулсан Их Монгол Улсын түүхэнд үлдээсэн гавьяат үйлийн талаар бусад улс орны төрийн тэргүүн нар, шашин соёлын алдартнууд ямар үзэл бодолтой байдаг талаар харьцуулан жишиж, агуулгаар нь багцлан сэдэвчилж судалжээ. Монголын эзэнт гүрнийг Чингис хаан байгуулсан нь засаглалын цоо шинэ хэлбэрийг үүсгэж, төрт ёсны төлөвшил, хууль цаазыг буй болгосон гэсэн санааг төр засгийн тэргүүнүүд захидалдаа дурджээ. Номыг зохиогч Чингис хааны хүн төрөлхтний хөгжилд байгуулсан гавьяа зүтгэлийг үнэлж, цэгнэсэн гадаад улсуудын төр, нийгмийн зүтгэлтнүүд, судлаач эрдэмтэн профессоруудын захидлыг нягтлан задлан шинжилж, нэгтгэн дүгнээд дараах түүхэн ач холбогдол байна гэж үзжээ. Өрнө дорныг холбосон хуурай болон далайн замыг бий болгож, дорно зүгт христ, лалын шашин дэлгэрэхэд, өрнөдөд одон орон судлал, тооны ухаан мэргэ төлөг, газрын зургийн технологийг нэвтрүүлэхэд, соёл, эдийн засгийн солилцоог түргэтгэснээр хөгжлийн үйл явцыг өөрчилсөн, орчин үеийн дипломат харилцааны ёс дэгийг тогтооход, иргэний харьяалалд тулгуурласан харилцан нөлөөлсөн соёл, шашин зэрэг үнэт зүйлс бий болгох цоо шинэ үндэстэн, нэгдмэл эзэнт гүрэн үүсэж төлөвших үйл явцыг эхлүүлсэн нь Чингис хаанаас хүн төрөлхтний өмнө байгуулсан үнэлж баршгүй гавьяа мөн хэмээн доктор Т.Баасансүрэн үзсэн байна<sup>3</sup>.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулсан “Их Монгол Улс”

хэмээх номын үнэ цэн, өгөөж нь Чингис хааны сургаал номлол, үзэл баримтлал амьдрал практикт амжилттай хэрэгжиж, Монголын төдийгүй дэлхийн олон улсын түүхэн хөгжилд хүчтэй нөлөө үзүүлснийг ийнхүү төр нийгмийн өндөр дээд албан тушаалтан, эрдэмтэн мэргэдийн судалгаа шинжилгээ, шашин соёлын нэрт зүтгэлтнүүдийн амаар хэлүүлж, бичгээр үйлдүүлж, баримт болгон баринтаглаж бичсэнээр батлагдаж байна.

Тавдугаар бүлэг. “Монголын нууц товчоо” нийтлэлийн бүтээл болохыг түүний бичлэгийн зарим арга хэлбэрээр тодотгон баталгаажуулах нь гарчигтай. “Монголын нууц товчоо”-г энэ бүлэгт сэтгүүлзүйн нийтлэлийн бүтээл болох талаас судлан шинжилсэн нэрт сэтгүүлч Х.Цэвлээ, доктор, профессор Л.Норовсүрэн нарын бүтээлд задлан шинжил хийж, өөрийн саналыг дэвшүүлэхийн зэрэгцээ сэтгүүлзүйн бичлэгт тохирох мэдээ мэдээллийг сонгон авч баяжуулан дэлгэрүүлжээ. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл болох мэдээ, сурвалжилга, тэмдэглэлтэй дүйцүүлж болох “Монголын нууц товчоо”-ны зүйлүүдээс жишээ болгон авч, онолын түвшинд тайлбарлан баримтаар баталсан байна. Тухайлбал “Монголын нууц товчоо”-ны 59 дүгээр зүйлийг “товч мэдээ” гэж үзээд, сэтгүүлч Х.Цэвлээ хэн? хаана?, юуг? яав? хэзээ? гэсэн асуулт тавьж, дээрх бичвэрийг задлан шинжилж, тодруулга, оруулгатай товч мэдээ мөн гэж<sup>4</sup> үзжээ.

Доктор Т.Баасансүрэн дээрх судлаачийн гурван мэдээг жишээ болгон авч тайлбар баримтаар баяжуулж, “Монголын нууц товчоо”-оос сонгодог хэлбэрийн мэдээг сонгон авч, задлан шинжилсэн байна. Доктор Т.Баасансүрэн “Монголын нууц товчоо”-г нийтлэлийн бүтээл мөн гэдэгтэй санал нэгдэн

тус бүтээлийн баримтын мөрөөр мөшгөж, уг зохиолыг монгол хэл рүү хөрвүүлсэн хэд хэдэн хувилбарыг харьцуулан судалж, уг зохиолын гол баатар Чингис хааны дэлхийн түүхэнд байгуулсан бодит гавьяа зүтгэлийг “Их Монгол Улс” хэмээх номын баримтаар нотлон харуулжээ. Тэрээр “Монголын нууц товчоо”-г бодит амьдралын бичиглэл бичээс мөн гэж үзэж судалгааны ажил, ном зохиол туурвисан олон эрдэмтэн мэргэдийн ном бүтээлээс эшлэл авч, сэтгүүл зүйн нийтлэл мөн болохыг улмаар тодотгож, XII-XIII зууны Монголын эзэнт гүрний үүсэл, хөгжил, мандан бадрал, төлөвшлийн үнэн бодит түүхийг өгүүлсэн нийтлэлийн бүтээл мөн хэмээн үзэж буйгаа олон баримтаар нотлон харуулжээ.

Зургаадугаар бүлэг. “Монголын нууц товчоо”-ны үг хэллэг, дүр дүрслэлийг нийтлэл зүйн үүднээс нягтлан задалж шинжих нь гарчигтай. Тус бүлэгт “Монголын нууц товчоо”-г зохиогч аман болон бичгийн хэлний уран тансаг хэллэг, дүр дүрслэл, зүйр цэцэн үг, сургаал, адилтгал зүйрлэлийг хэрхэн бүтээлдээ ашиглаж, уншихад уран яруу болгож чадсаны нууцыг задалж шинжлэн баримттай өгүүлжээ. Ингэхдээ “Өвгөдийн үгийг өв болгож, хуучны үгийг хууль болгож явахыг хойч үеийнхэндээ сургаж гэрээсэлж үлдээсэн нь”, “Монгол үгсийн сан хөмрөгөөс алтан сондор мэт адилтгал зүйрлэл, зүйр цэцэн үгсийг самран шүүрдэж сорчлон хэрэглэсэн нь”, “Шүлэглэсэн хүүрнэл дүрслэлт үг хэллэгийн тухайд” гэсэн гурван дэд гарчгийн дор энэ бүлгээ бичсэн байна. “Монголын нууц товчоо” өвгөд дээдсийнхээ баялаг сургаалаар үр хойчоо хүмүүжүүлж, сургаж байсны тод томруун жишээг уг бүтээлийн 22, 25, 26, 117, 126 дугаар зүйлүүдийн баримтаар эш татаж

тайлбарлажээ. Тухайлбал “Монголын нууц товчоо”-ны 22-р зүйлд “Эв эе”-тэй байхыг сургамжилсан бол 24, 25-р зүйлд “Эрийг бүү бас, далайг бүү янд” гэдгийг, 117, 126-р зүйлд “Ихэс дээдсийн үг сургаал, анд нөхрийн эрхэм ёс” түшиг тулгуурын талаар сургаж захисан байх жишээтэй аж.

**С**удлаач Т.Баасансүрэн “Монголын нууц товчоо”-г цэцэн мэргэн үгсийн далай, адилтгал зүйрлэл, сургаалаар хэтэрхий баян бүтээл гээд тэдгээрийг утга агуулгаар нь өдөр тутмын аж амьдралтай холбоотой үг хэллэг, гүн ухааны өнгө аястай хэллэг хэмээн ангилж, баримт түшин үйл явдлын учир холбогдлоор задлан шинжилж тайлбарласан байна.

“Монголын нууц товчоо”-ны 78-р зүйлд Өэлүн эх хөвүүдээ зэмлэн буруушаахдаа: “Хавиргаа хазах хар нохой мэт, хаданд довтлох харцага шонхор мэт...” хэмээн агуулгыг аж төрөх ёсны адилтгал зүйрлэлээр, “Ботго торомны борвийг хазах өл буур мэт, нялх үрээ гилэн \хөөн\ ядаж нядлан идэх нүгэлт ангир мэт” гэх зэргээр ан амьтны дүр төрх, ааш авиртай холбож насандаа мартагчгүйгээр ойлгох нь оруулж зүйрлэн хэлж, зэмлэж үр хүүхдүүдээ сургаж байсныг эш татжээ.

“Монголын нууц товчоо”-ны 147-р зүйлд “Харцага шонхор мэт харайлдан дүүлэн явъя, ангир шувуу мэт амраг үрээ бүү хөнөөе”, “Цатгалан могой шургах завсаргүй”, “Харцагаас зугтсан болжмор мэт хандгай бугын мөрийг дагаж”, “нисэх шувуу, хийсэх салхи мэт”, “Хамаатан садан мэт эвлэлдэж, харийн дайсныг хамх цохъё” гэх мэтээр хүнд хүргэх санаагаа ил тод хэлж сайн үгийг сайшаан зүйрлэж, муу муухайг илчлэн шүүмжилж, хулчгар худалч чанар, эрдэм ухааны ач тус хийгээд мулгуу мунхгийн хор уршиг, зусар бялдууч

залхуу хойрго байдлыг ч аж төрөх байдлын зүйр цэцэн үгс, адилтгал зүйрлэлээр оновчтой илэрхийлэн гаргаж хэлдэг уламжлал зан заншил монголчуудын яс цусанд буйг “Монголын нууц товчоо”-ны олон арван жишээ нотлон харуулж байгааг цөөн хэдээр төлөөлүүлэн дурдахад ийм байна. Доктор Т.Баасансүрэн уг бүтээлд байгаа мэргэн цэцэн үгийн цоморлог аж төрөх ёсны илэрхийлэл болсон олон арван жишээг сонгон авч, задлан шинжилж, тайлбарлажээ. Шүлэглэсэн хүүрнэл дүрслэлт үг хэллэгийн тухайд шүлэг найраг шиг эгшиглэнтэй, шүлэглэсэн байдал нь хайлах туульс шиг, дуулах дууль адил сонсголонтой өвөрмөц давтагдашгүй чанар “Монголын нууц товчоо”-нд бий хэмээгээд 55, 57, 74, 93, 193, 254-р зүйлийг жишээлжээ. “Одтой тэнгэр орчиж, олон улс байлдаж, орондоо унтах завгүй олзлон булаалдаж байв ... эргэлзэн бодох чөлөөгүй элбэлдэн зүтгэж явав, ухран дутаах газаргүй урагшлан байлдаж явав, амар жаргах аргагүй алалдан тэмцэж байв” хэмээн дуу алдам ард түмнүүдийн тэмцэл тулалдааныг ингэж онож хэлсэн зохиол нүүдэлчдийн түүхэнд лав байхгүй байх үүнд тус бүтээлийн аугаа үнэ цэн оршино гэж үзсэн байна. Тэрээр дээрх уран цэцэн үг хэллэгтэй дүр дүрслэлийн утгыг нэг бүрчлэн тайлбарлаж, “Монголын нууц товчоо”-ны үгийн ур хийц, яруу тансаг дүрслэл тус бүтээлийн давтагдашгүй үнэ цэн мөн болохыг тодотгожээ. Доктор Т.Баасансүрэн тус бүтээлийн адилтгал зүйрлэлийг торго нэхэх адил, тор сүлжих адил, уран зөгий үүрээ урлах адил, дархан хүн ухаанаа чагтлан унь тооноо угалзлуулах адил хэмээн зүйрлэж, уран үгсийг шүр сувд хэлхэх мэт, үгийн хүдрийн дээжийг ширхэг ширхгээр шүүрдэж сартай шөнийн

тэнгэрт од мичид жирвэлзэн гялтганах адил ончтой үгийг сүлжилдүүлсэн нь зүрх сэтгэлийг жигүүрлүүлэн булгилуулах төдийгүй үг хэллэг, үг өгүүлбэр бүр нь нүдийг соронздон татаж баяр баясал, бишрэл гайхширлыг төрүүлэхүйц утга агуулга, дүр дүрслэлийг найрсуулсан нь хан тэнгэрээс асгаран буусан мэндрийн мөнгөн дуслууд мэт үнэхээр гайхалтай хэмээн “Монголын нууц товчоо”-ны дүр дүрслэлт үг хэллэгийг үнэлжээ.

Сэтгүүл зүй судлаач, доктор Баасансүрэн “Монголын нууц товчоо”-нд байгаа шиг дүр дүрслэлт үг хэллэгийг өнөө үеийн сэтгүүлч, нийтлэлчид бүтээлдээ хэрэглэх нь өдрийн од шиг байгаа хэдий ч эрх биш жишээ татах нийтлэл цөөн хэдийг дурджээ. Тухайлбал “Үндэсний тойм” сэтгүүлд “Таталцал нууцлаг үзэгдэл” гэсэн эрдэм шинжилгээний нийтлэлд “Таталцлын долгион нь бидний орон зайг дайрч өнгөрөхдөө манай дэлхийг өчүүхэн бага хэмжээгээр “устай гүзээ шиг цэлцэгнүүлээд өнгөрсөн ажээ” гэсэн нь нүдэнд харагдах шиг дүрслэлт үг хэллэгийн ид шид гэдэг энэ. Мөн сэтгүүлч Ганчимэг сүмогийн их аварга Д.Дагвадоржтой хийсэн ярилцлагадаа “сүмогийн дэвжээнд азаргалсан” шүү дээ хэмээх хэллэгийг монгол ахуйтай холбосон нь, Б.Ганбат “Эх” эсээ “алаг нүдэндээ нулимс мэлмэрүүлэн,

мэлтэлзүүлэн бүүвэйлжээ” гэж хэлэхэд уншигч танд эрхгүй нэгийг бодуулж байгаа. Нийт сэтгүүлчид ингэж л бичмээр хэмээжээ.

Дүгнэлт: Сэтгүүлч, сэтгүүл зүй судлаач, шүүмжлэгч доктор профессор Т.Баасансүрэнгийн “Монголын нууц товчоо” нийтлэлийн дурсгалт бичиг мөн судалгааны томоохон бүтээл “Монголын нууц товчоо” судлалд цоо шинэ зам гаргасан өвөрмөц онцлогтой судалгаа болжээ.



**“Монголын нууц товчоо”-г нийтлэлд хамаатуулан судлахдаа доктор Т.Баасансүрэн тус бүтээлийн гүнд нэвтэрч, мөр бүхнийг нь мөрлөн үг бүрийг нь шинжин үнэний эрэлд мордож, эрлээ олжээ. Тус бүтээлийг хятад эхээс анх галиглан буулгасан гүн Цэндийн орчуулгыг, Ш.Чоймаагийн “Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг”, академич Ц.Дамдинсүрэн, Д.Цэрэнсодном нарын хөрвүүлэгтэй тулган нягталж, утга агуулгын зөрөөтэй орчуулгыг тодруулан гаргаж харьцуулалт хийсэн байна**



“Монголын нууц товчоо”-г нийтлэлд хамаатуулан судлахдаа доктор Т.Баасансүрэн тус бүтээлийн гүнд нэвтэрч, мөр бүхнийг нь мөрлөн үг бүрийг нь шинжин үнэний эрэлд мордож, эрлээ олжээ. Тус бүтээлийг хятад эхээс анх галиглан буулгасан гүн Цэндийн орчуулгыг, Ш.Чоймаагийн “Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг”, академич Ц.Дамдинсүрэн, Д.Цэрэнсодном нарын хөрвүүлэгтэй тулган нягталж, утга агуулгын зөрөөтэй орчуулгыг тодруулан гаргаж харьцуулалт хийсэн байна.

Мянганы суут хүнээр тодорсон Чингис хааны хүн төрөлхтөнд оруулсан түүхэн гавьяат үйлсийг “Их Монгол Улс” номын агуулгад дүн шинжилгээ хийх замаар долоон түүхэн ач холбогдол байгааг илрүүлжээ.

“Монголын нууц товчоо” нийтлэлийн бүтээл мөнийг түүний

бичлэгийн зарим хэлбэрээр тодруулахдаа тус бүтээлийг сэтгүүлзүйн аргаар судлан өөрийн зохиол бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэлд тусгасан эрдэмтдийн судалгааг жишээлэн тайлбарлаж, “Монголын нууц товчоо”-ны баримтаар баяжуулсан байна.

Доктор Т.Баасансүрэн уг бүтээлийн үг хэллэг, дүр дүрслэлийг нийтлэл зүйн үүднээс нягтлан үзэж, адилтгал зүйрлэл, зүйр цэцэн үгсийг хэрхэн яаж онч мэргэнээр ашиглаж, хүний сэтгэлийг татаж, нийтлэлийн үр нөлөөг дээшлүүлж болдгийн үлгэр загварыг бэлхэн харуулсан баримтат нийтлэлийн дээж бичиг мөн хэмээн тодорхойлжээ.

“Монголын нууц товчоо” судлалын эх хувилбаруудыг судлан шинжилсэн, хөрвүүлсэн эрдэмтдийн талаар судлаач номын нэгдүгээр бүлэгт дэлгэрэнгүй маш тодорхой авч үзсэн боловч гурав болон зургаадугаар бүлэгт мөн сануулах маягаар дахин дахин давтсан тал ажиглагдлаа.

#### Эшлэл

- 1 Баасансүрэн.Т. Монголын нууц товчоо-нийтлэлийн дурсгалт бичиг мөн. УБ., 2017. х.95.
- 2 Баасансүрэн.Т. Монголын нууц товчоо-нийтлэлийн дурсгалт бичиг мөн. УБ., 2017. х.152.
- 3 Баасансүрэн.Т. Монголын нууц товчоо-нийтлэлийн дурсгалт бичиг мөн. УБ., 2017. х.273.
- 4 Улаанбаатар Эрдэм Их Сургууль. ЭШБ. №9. УБ., 2015/2016. х. 179.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн.Т..«Монголын нууц товчоо»-г хөрвүүлсэн хоёр хувилбарт хийсэн зарим ажиглалтыг Цэнд гүнгийн анхдагч орчуулга, Ш.Чоймаагийн эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай

шинэ хөрвүүлэгтэй тулган нягталж сурвалжлахуй. УБЭИС. ЭШӨ. УБ. 2014.

2. Баасансүрэн. Т. Хүн төрөлхтний хөгжилд Монголын эзэнт гүрэн, «Мянганы суут хүн» Чингис хааны гүйцэтгэсэн үүрэг, түүхэнд түүний эзлэх байр суурь. ЭШӨ. УБ. 2018.
3. Баасансүрэн. Т. «Монголын нууц товчоо» нийтлэлийн бүтээл болохыг түүний бичлэгийн зарим хэлбэрээр тодотгон баталгаажуулах нь. ЭШӨ. УБ. 2014.
4. Баасансүрэн. Т. Монгол үгсийн сан хөмрөгөөс алтан сондор мэт адилтгал зүйрлэл, зүйр цэцэн үгсийг самран шүүрдэж сорчлон хэрэглэсэн нь. ЭШӨ. УБ. 2017.
5. Баасансүрэн. Т. «Монголын нууц товчоо-нийтлэлийн дурсгалт бичиг мөн». УБ. 2014.
6. Баасансүрэн. Т. Монголын нууц товчооны үг хэллэг, дүр дүрслэлийг нийтлэл зүйн үүднээс нягтлан задалж шинжих нь. УБ. 2016
7. Баасансүрэн.Т. 2017. МУИС. Сэтгүүл зүй. ЭШБ. №18. (479). УБ.
8. Баасансүрэн.Т. 2016. МУИС.ШУС.НУС. Сэтгүүл зүй. ЭШБ., №17.(457). УБ.

#### Summary

The book «"The Secret Word of the Mongols" is a written monument to journalism», which had written in 2014 and presented to readers in 2017 with an addition of another chapter, has become a special work that has made a new contribution to the science. In the scientific article “Some features of the work of journalism studies by Doctor, Professor T. Baasansuren”, the aim was to clarify that T. Baasansuren is a researcher who made a valuable contribution to the development of research in the field of journalism, and this time I tried to conduct a professional analysis of one work of the scientist, my teacher, who created a completely new direction in the study of journalism, and show its features.